

# “ Э-ТРАНС ЛОЖИСТИКС “ ХК-НЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## 1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- **Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг;**  
Хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1-р баг 10-р хэсэг, Э-Транс Ложистикс ХК-ны байр  
Утас: 02524543813, 99117636, 99991451  
Электрон хаяг: [www.etr.mn](http://www.etr.mn)
- **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл;**  
Компанийн нэр: “ Э-транс Ложистикс “ ХК  
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2011.12.06  
Улсын бүртгэлийн дугаар: 0610001001  
Регистрийн дугаар: 3309665  
Үйл ажиллагааны чиглэл: Ачаа шилжүүлэн ачих терминал  
Хувьцаа эзэмшигчдийн тоо:
- **Товч танилцуулга;**



Э-Транс ложистикс Хувьцаат компанийн хяналтын багцыг эзэмшигч Э-Транс Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 2007 оноос Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багийн нутагт төмөр зам дагасан байрлалд салбар зам барин ачаа шилжүүлэн ачих терминал байгуулах төсөл хэрэгжүүлснээр манай компанийн үйл ажиллагааны эхлэл тавигдсан.

2007-2008 онд шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтыг хийж ашиглалтанд оруулсан бөгөөд 2009 оны 4 дүгээр сард анхны тээврийн хэрэгслээс вагонд шилжүүлэн ачих ажлыг хийж гүйцэтгэсэн.

2010 онд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагааг тусгаарлан Э-Транс ложистикс хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлсэн.

2012 оны 04 сард Монголын Хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн хувьцаат компани болсон ба 924 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татан техник тоног төхөөрөмж, барилга байгууламж, дэд бүтцээ сайжруулах, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулсан.

## **1. КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### **1.1 Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;**

2019 оны 04 сарын 25-нд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2019 онд тус компаниас хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. 2019 онд тус компани үндсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, компанийн хөрөнгө орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээний нэр төрлийг олшруулах ажлуудыг хийж гүйцэтгэх, үүнтэй уялдаад зарим техник технологийн шинэчлэлтийг хийх зэрэг ажлуудыг багтаасан нийт 4 бүлэг, 9 хэсэг, 43 ажлыг төлөвлөсөн.

Төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр тооцож ажиллаж байгаа бөгөөд 2019 оны хагас, бүтэн жилийн төлөвлөгөөний биелэлтийг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, стратегиа төлөвлөсөн ба төлөвлөгөөний биелэлтэнд гүйцэтгэх удирдлагаас хяналт тавьж ажиллахыг үүрэг болгож ажилласан боловч компанийн үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр доголдсонтой холбоотой зарим хөрөнгө санхүү шаардлагатай ажил үйлчилгээнүүд хийгдэх боломжгүй болсон бөгөөд цаашид хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн ажлуудыг 2020 онд хийхээр төлөвлөж байна.

### **1.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;**

Тус компани нь Дорноговь аймгийн Замын-үүд суманд адил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд дотроо Улаанбаатар төмөр зам ХНН-ийн Замын-Үүд өртөөний шилжүүлэн ачих ангитай шилжүүлэн ачилтын тодорхой төрлүүдэд өрсөлдөх байр суурьтай байна. Үүнээс гадна тус нутаг дэвсгэрт Монголын төмөр зам ТӨХК-ны Замын-Үүд ложистикийн төв үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон байгаа ба одоогоор ажиллаагүй байгаа боловч ажиллаж эхэлсэн тохиолдолд тус компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын үйлчилгээ нь нутаг дэвсгэр дэх байр сууриа тодорхой хэмжээгээр алдах асуудалтай байгаа болно. Гэхдээ шилжүүлэн ачилтын хувьд байр сууриа алдаж байгаа боловч компанийн бусад үйлчилгээний салбар болох гаалийн хяналтын бүс, баталагаат агуулах зэрэг үйл ажиллагаа, үйлчилгээгээрээ нутаг дэвсгэртээ тэргүүлэх байр сууриа хадгалсан хэвээрээ байгаа юм.

Өнөөдрийн байдлаар тус бүс нутагт доорх хүснэгтэн дэх аж ахуйн нэгжүүд шилжүүлэн ачилт болон гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эрхэлж байна.

д/д	Хяналтын бүсийн нэр	Зориулалт	Онцлог	Байршил, утасны дугаар
1	Авто замын цогцолбор 2/ачааны/	Төрөл бүрийн	Хяналтын бүстэй, агуулахгүй	Дорноговь аймаг, Замын-Үүд сум, утас 96361281
2	Замын-Үүд өртөө 1 / өргөн төмөр зам/	Төрөл бүрийн	Салбар замтай, агуулахгүй	Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, Төмөр замын вокзал, утас 43297, 86112301
3	Нарийн төмөр замын шилжүүлэн ачих анги	Төрөл бүрийн	Нарийн цариг, агуулахгүй	Дорноговь аймаг, Замын-Үүд сум
4	Э-Транс ложистикс ХК	Төрөл бүрийн	Салбар замтай, хяналтын бүс, агуулахтай	Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1-р баг, 10-р хэсэг утас 90990998
5	Дардан ложистик	Төрөл бүрийн	Салбар замгүй, агуулахгүй	Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1 дүгээр баг, Төмөр замчдын өргөн чөлөө, утас 70117303, 99095636
6	Сауд Гэйт	Нурмаг ачаа шилжүүлэн ачих	Салбар замтай, агуулахгүй	Дорноговь аймаг, Замын-Үүд сум, 1 дүгээр баг, утас 91117309, 90990998
7	Русалт	Шилжүүлэн ачих, буулгах	Салбар замтай агуулахгүй	Дорноговь аймаг, Замын-Үүд, УБТЗ ХНН-ийн шилжүүлэн ачиж, буулгах ангийн 1 дүгээр талбайд, утас 99006608, 99135905
8	Замын-Үүд Ложистик төв	Төрөл бүрийн	Салбар замтай агуулахтай	Дорноговь аймаг, Замын-Үүд сум, Бүс нутгийн ложистикийн төв, утас 70006622, 99011551
9	Чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмж	Төрөл бүрийн	Хяналтын бүстэй, агуулахгүй	Дорноговь аймаг, Замын-Үүд сум, авто замын шалган нэвтрүүлэх боомтоос 3 км зайд, утас /025-245/-43222, 96361281

### **1.3. Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;**


2019 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны нөхцөл байдлыг дүгнэж үзэхэд тус компанийн гол үйл ажиллагаа болох шилжүүлэн ачих үйл ажиллагаа ихээхэн доголдож зогсонги байдалтай байгаа ба энэ байдал ойрын жилүүдэд ч үргэлжлэх нөхцөл байдалтай байна. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд

суманд ажиллан тус компанийн үйл ажиллагаатай газар дээр нь ирж танилцан, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулан зарим тодорхой асуудлуудыг шийдвэрлэж ажилласан.

**Хүснэгт 1.** Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:

Сар	Барилгын төрөл бүрийн материал	Кран	Модон материал	Бусад	Нийт
1.	24	1	12	5	43
2.	6		2		8
3.	27	3	11	6	42
4.	33	5	19	9	71
5.	59	2	11	13	85
6.	45	13	3	20	82
7.	34	12	5	7	58
8.	27	3	10	8	48
9.	28	3	2	10	43
10.	13			3	16
11.	14	1	2	5	22
12.	15		25	5	42
Нийт	325	43	102	91	560

**График 1.** 2017, 2018, 2019 онуудын ачилтыг харьцуулсан байдал



Дээрх графикаас харвал шилжүүлэн ачилт сүүлийн 3 жилд бүх төрлүүд дээр тогтмол буурсан үзүүлэлттэй гарсан нь харагдаж байна. Шилжүүлэн ачилт буурч байгаагийн гол шалтгаан нь тус компаниар үйлчлүүлэх иргэд аж ахуйн нэгж багассан, шилжүүлэн ачилтын гол хэрэглэгдэхүүн вагон тавьж олгох байдал төмөр замаас хараат байдгаас болж байгаа гэж үзэж болно. Төмөр замын байгууллага өөрийн ажлын ачааллыг харгалзан компанийн салбар замд вагон олгох байдал багасч үүнийг дагаад үйлчлүүлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд вагон хүлээж цаг

хугацаа алдахыг хүсэхгүй Замын-Үүд өртөөгөөр ачаагаа тээвэрлүүлэх болсонтой холбоотой юм.

#### **1.4. Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;**

Шилжүүлэн ачилтын байдал жилээс жилд тогтмол буурч байгаа боловч Төлөөлөн удирдах зөвлөл болон компанийн удирдлага энэ байдалд дүгнэлт өгч зарим өөр төрлийн ачаа барааг шилжүүлэн ачих нөхцөл бололцоог судлаж зарим аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар bigbag савалгаатай нурмаг ачааг тээврийн хэрэгслээс тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих ажлыг өөрсдийн техник хэрэгсэл, ажиллах хүчний нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэх ажлыг эхлүүлээд байгаа ба энэ ажлыг цаашид үргэлжүүлэн хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Шилжүүлэн ачилт ингэж огцом буурч байгаа ч компанийн бусад үйл ажиллагаа болох гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахад ачаа бараа хадгалах үйлчилгээ тодорхой хувиар нэмэгдсэн. Замын-Үүд боомтын өргөтгөлийн ажил хийгдэж боомтод гаалийн бүрдүүлэлт хийгдэж байсан зарим төрлийн ачаа барааг тус компанийн гаалийн хяналтын бүс рүү шилжүүлсэн нь дээрх үйлчилгээ нэмэгдэхэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн боловч компанийн удирдлагаас холбогдох байгууллагатай хамтран өмнөх жилүүдэд эхлүүлсэн экспортын ачаа барааг тяс хяналтын бүсээр дамжуулан гаргаж жин тонныг баталгаажуулах, хяналт шалгалтыг нэг цэг дээр төвлөрүүлэхээр хийгдсэн ажлын үр дүн мөн энэ өсөлтөнд нөлөөлсөн гэж үзэж болно.

2017, 2018 онд орлогын тодорхой хувийг эзэлж байсан чингэлэг буулгах үйлчилгээ нь машин импортолж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанаас шалтгаалан 2 дахин буурсан.

#### **Хүснэгт 2. Пүүлсэн экспортын ачааны тоо**

мян.төг

Он	Экспортын ачааны тоо		Пүүлсэн үйлчилгээний хураамж	
	2018 он	2019 он	2018 он	2019
1 сар	60	147	1,091	2,672.7
2 сар	25	36	455	654.5
3 сар	120	102	2,182	1,854.5
4 сар	150	154	2,272	2,800.0
5 сар	160	170	2,909	3,090.9
6 сар	80	144	1,455	2,618.2
7 сар	85	181	1,545	3,290.9
8 сар	201	214	3,655	3,890.9

<b>9 сар</b>	234	176	4,255	3,200.0
<b>10 сар</b>	284	456	5,164	8,290.9
<b>11 сар</b>	321	249	5,836	4,527.3
<b>12 сар</b>	336	526	6,109	9,563.6
<b>Нийт</b>	<b>2056</b>	<b>2555</b>	<b>37,381.8</b>	<b>46,454.5</b>

**Хүснэгт 3. Чингэлэг буулгах үйлчилгээ**

мян.төг

Он	Импортоор орж ирсэн чингэлэгийн тоо		Тээврийн хэрэгсэл буулгах үйлчилгээний хураамж	
	2018 он	2019 он	2018 он	2019 он
<b>1 сар</b>	-	8	-	1,454.5
<b>2 сар</b>	2	5	363.6	909.1
<b>3 сар</b>	5	5	909.1	909.1
<b>4 сар</b>	2	3	363.6	545.4
<b>5 сар</b>	10	8	1,818.2	1,454.5
<b>6 сар</b>	20	5	3,636.4	909.1
<b>7 сар</b>	6	8	1,090.9	1,454.5
<b>8 сар</b>	13	3	2,363.6	545.4
<b>9 сар</b>	15	3	2,727.3	545.4
<b>10 сар</b>	13	3	2,363.6	545.4
<b>11 сар</b>	8	1	1,454.5	181.8
<b>12 сар</b>	9	0	1,636.4	0
<b>Нийт</b>	<b>103</b>	<b>52</b>	<b>18,727.2</b>	<b>9,454.5</b>


Доорх хүснэгтээр өмнөх жилүүдэд буюу 2015-2019 оны байдлаар шилжүүлэн ачилтын үйлчилгээний өсөлт бууралтыг харуулав. Энэ нь улс орны эдийн засгийн байдал компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж өсөж буурч байгааг харуулж байна.

**Хүснэгт 4. 2014-2019 онуудад ачигдсан вагоны тоо / сараар /**

Сар	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
<b>1.</b>	170	100	108	28	55	43
<b>2.</b>	70	76	82	20	30	8
<b>3.</b>	334	439	191	37	55	42
<b>4.</b>	301	955	554	133	87	71
<b>5.</b>	291	946	699	136	111	85
<b>6.</b>	301	921	518	182	141	82
<b>7.</b>	450	989	376	142	95	58
<b>8.</b>	652	1062	312	111	113	48
<b>9.</b>	451	946	106	99	93	43

10.	231	647	59	83	73	16
11.	132	154	41	65	63	22
12.	156	134	19	81	49	42
Дүн	<b>3,539</b>	<b>7369</b>	<b>3069</b>	<b>1117</b>	<b>965</b>	<b>560</b>

**График 2. 2014-2019 оны ачилт, буултын харьцуулсан үзүүлэлт / жилээр /**



Төмөр замаар ирж Хятад улс руу экспортлогддог түүхий эдийг шилжүүлэн ачих ажиллагаа (буулт) нь 2012 оноос тогтмол буурч байгаа бөгөөд үүний шалтгаан нь түүхий эдийн экспорт автозамаар тээвэрлэгдэх болсонтой холбоотой юм. 2019 оны байдлаар тээврийн хэрэгслээр тээвэрлэгдэж байгаа экспортын ачаа бүр тус компанийн гаалийн хяналтын бүсээр дамжин жин тонны баталгаажуулалт, хяналт шалгалтын ажлыг хийгдэж гарч байгаа бөгөөд 2842 тээврийн хэрэгсэл бүхий экспортын ачаа хяналтын бүсээр дамжин өнгөрсөн байна.

**Хүснэгт 5. Орлогыг нэр төрлөөр нь харуулсан нь /мян төгрөг/**

д/д	Орлогын нэр	2018 он	2019 он	Зөрүү	Өсөлт/ бууралт/
1	Ачилтын орлого	168,949.82	89,620.2	-79,329.62	-47% буурсан
2	Буултын орлого	320.00	1,200.0	880.00	2 дахин өссөн
3	Хадгалалт болон гарах хуудас	325,964.91	490,790.1	164,825.19	33% өссөн
4	Түрээсийн орлого	44,136.36	45,772.7	1,636.34	3,5% өссөн
5	Бусад орлого	171,350.27	264,231.9	92,881.63	35% өссөн

Хойно гарах орлого үр дүнгийн тайланд бусад орлогод тусгагдсан цайны газрын орлогоос хоолны материалын зардлыг хассан дүнгээр орлогыг тооцсон болно.




**Хүснэгт 6. Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн машины тоо хураамж**

Сар	Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл		Хяналтын бүс болон агуулахад ачаа бараа хадгалсны хураамж
	Тоо	Хураамж	
1 сар	667	8,422.70	38,888.00
2 сар	235	6,891.10	8,660.00
3 сар	1003	12,729.10	20,408.00
4 сар	1250	25,585.90	8,202.00
5 сар	1763	26,592.70	14,086.90
6 сар	1658	34,125.50	59,585.00
7 сар	1283	18,789.10	3,162.30
8 сар	1464	24,450.00	8,430.80
9 сар	1378	21,816.40	-
10 сар	1136	26,963.60	16,429.60
11 сар	758	23,125.50	11,554.00
12 сар	520	7,861.80	64,060.10
<b>Нийт дүн</b>	<b>13115</b>	<b>237,353.40</b>	<b>253,436.70</b>

Гаалийн хяналтын бүсэд 2019 оны байдлаар 13115 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь хилийн боомтын өргөтгөлийн ажил хийгдэж байгаатай холбогдуулж тус хяналтын бүсэд хийгдэж байсан зарим төрлийн ачаа барааг манай гаалийн хяналтын бүс рүү шилжүүлсэнтэй холбоотой боловч сүүлийн үеийн эдийн засгийн тааламжтай байдал мөн шууд нөлөөлсөн гэж үзэж болно. Хяналтын бүсэд нэвтэрч хяналт шалгалтын хугацаанд ачаа бараагаа хадгалуулсан 13115 тээврийн хэрэгсэл дээр экспортын ачаа бараа ачсан тээврийн хэрэгсэлээ нэмж тооцвол 15670 тээврийн хэрэгсэл тус гаалийн хяналтын бүсэд нэвтэрч хяналт шалгалт хийлгэн хадгалуулсан байна.

**График 3. Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл**



Гаалийн хяналтын бүсэд 2019 оны байдлаар 13115 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2587-аар буюу 19.7 хувиар өссөн.



Мөн сүүлийн жилүүдэд зогсонги байдалд байсан уул уурхайн салбар 2018 оноос сэргэсэнтэй холбоотойгоор уул уурхайн техник тоног төхөөрөмж импортлогч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа идэвхижсэнтэй холбоотойгоор тус гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахад хадгалах техник, тоног төхөөрөмж ихссэн ба мөн харилцагч байгууллагуудтай нягт хамтран ажилласны дүнд хадгалалтын орлого өмнөх оны мөн үеийнхээс 35%-иар өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5 Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан


Тус компани нь үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа буюу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь байгууллага, аж ахуйн нэгжийн дунд томоохонд орох татвар төлөгч аж ахуйн нэгж юм.

2013-2018 онд төлсөн татварын хэмжээг хүснэгтээс харвал:

Татварын төрөл	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Үл хөдлөх хөрөнгийн орлогийн татвар	47,593,936	47,953,936	28,556,365	17,940,365	40,330,275	19 730 269
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	464,740	574,900	482,275	299,940	534,540	981 450
Газрын төлбөр	400,000	400,000	400,000	400,000	400,000	7 500 000
Нэмэгдсэн өртгийн орлогын татвар	42,310,698	43,335,267	59,446,662	39,042,992	38,000,000	62 040 928
Хувь хүний орлогын татвар	16,472,167	20,397,566	22,411,896	12,989,953	24,729,833	22 172 326
Аж ахуйн нэгжийн орлогын татвар	23,065,456	27,623,094	122,285	0	4,643	
<b>Нийт дүн</b>	<b>130,306,997.00</b>	<b>140,284,763</b>	<b>111,419,483</b>	<b>70,673,250</b>	<b>103,999,291</b>	<b>112 424 973</b>

Жич: Голлох татварын хэмжээг харуулав.

Үүнээс гадна нийгмийн даатгалын санд төлсөн даатгалын шимтгэлийг харвал:



## 1.6 Нийгмийн хариуцлагын тайлан

Замын-Үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвор суурьшил муу, шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоо ажлын тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл байдал доголдолтой байдаг нь ажилд сөргөөр нөлөөлдөг. Иймээс бид орон нутгийн харъяат иргэдээс залуу боловсон хүчнийг сургах, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэн компанидаа ажилуулах тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна. Одоогийн байдлаар тус компанийн нийт 30 ажилчдаас 25 нь буюу нийт ажилчдын 83,3%-ийг Замын-Үүд суманд оршин суудаг, сумын харъяат иргэд эзэлж байгаа бөгөөд үлдсэн 5 буюу 16,7%-ийг түр оршин суугч иргэд эзэлж байна.

Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр түлхүү анхаарч ажиллаж шаардлагатай зээл тусламж авахад дэмжлэг үзүүлэх, нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярыг хамт олон, гэр бүлээрээ тэмдэглэх, спортын болон хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Замын-Үүд сумын Засаг даргын захирамжаар тус нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагууд сар болгоны эхэнд байгууллагынхаа гадна орчны цэвэрлэгээг тогтмол хийх үүргийн хүрээнд гадна орчны цэвэрлэгээ, мод бут арчлах ажлыг хийж, ногоон байгууламжаа засаж сэлбэх ажлыг тогтмол хийсэн.

Ажилчдийнхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд түлхэц үзүүлэх үүднээс давхардсан тоогоор 15 ажилчинг цалингийн болон бусад төрлийн зээл авахад тодорхойлолт гаргаж өгөх, харилцагч банкны эдийн засагч болон холбогдох хүмүүсийг ажлын байранд авчирч уулзалт, танилцуулга хийх зэрэг ажлуудыг хийхээс гадна ажилчдынхаа цаашид ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх үүднээс оны эцэст ажилчдын ажлыг үнэлж дүгнэн 8 ажилчинг хөдөлмөрийн аварга ажилтнаар шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан.

## 2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### 2.1. Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

Компанийн удирдлагын бүтцэд өөрчлөлт ороогүй болно.

### 2.2. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

#### Гүйцэтгэх удирдлага

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, эдийн засгийн математик загварчлал, нягтлан бодогч, бизнесийн	2011 оноос хойш ажиллаж байна.

			удирдлагын магистр	
3.	Хаваан Батхишиг	Менежер	Дээд, бизнесийн удирдлага	2012 оноос хойш ажиллаж байна.
4.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.

### Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн 2018 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон.

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1.	Энхболдын Батболд	ТУЗ-ын дарга, хараат гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Дэд захирал
2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
3.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Гүйцэтгэх захирал
6.	Шараагийн Шинэбаяр	ТУЗ-ын хараат гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, хөрөнгө оруулалтын менежер
7.	Алтангэрэлийн Цэнгэл	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Рейлнет ХХК, Дэд захирал
8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Лайф ис Гүүд Монголиа ХХК, нягтлан бодогч
9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	Дээд	Хувиараа

**2.3 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл**

д/д	Овог нэр	Албан тушаал	Цалин урамшууллын хэмжээ	Эзэмшиж буй хувьцааны тоо
Төлөөлөн удирдах зөвлөл				
1.	Энхболдын Батболд	ТУЗ-ын дарга, хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
2.	Чулууны Энхболд	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй

3.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын хараат гишүүн, гүйцэтгэх захирал	сарын 1.100.000	Эзэмшдэггүй
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
5.	Данзангийн Даянбилгүүн	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
6.	Шараагийн Шинэбаяр	ТУЗ-ын хараат гишүүн	0₮	Эзэмшдэггүй
7.	Алтангэрэлийн Цэнгэл	ТУЗ-ын хараат бус гишүүн	0₮	Эзэмшдэггүй
8.	Жаргалсайханы Энхтулга	ТУЗ-ын хараат бус гишүүн	0₮	Эзэмшдэггүй
9.	Чулуунбаатарын Оргил	ТУЗ-ын хараат бус гишүүн	0₮	Эзэмшдэггүй
Гүйцэтгэх удирдлага				
1.	Эрдэнэбаатарын Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Сарын 1.500.000₮	Эзэмшдэггүй
2.	Хавааны Батхишиг	Менежер	Сарын 1.500.000₮	Эзэмшдэггүй
3.	Гомбын Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Сарын 1.300.000₮	Эзэмшдэггүй
4.	Ванданлхүндэвийн Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Сарын 900.000₮	Эзэмшдэггүй

#### 2.4. ТУЗ болон түүний дэргэдэх хороод

д/д	Овог нэр	Эзэмшсэн мэргэжил, боловсрол	Хараат бус гишүүн эсэх	ТУЗ-ын хороодод томилогдсон байдал
1.	Энхболдын Батболд	Тайваны их сургууль, эрх зүйч	Хараат	Нэр дэвшүүлэх хорооны дарга
2.	Чулууны Энхболд	Ленинградын Төмөр замын дээд сургууль, Төмөр замын инженер	Хараат	
3.	Чулууны Амарсанаа	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль, Уулын инженер	Хараат	
4.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ШУТИС, нефтийн инженер	Хараат бус	Аудитын хорооны дарга
5.	Данзангийн Даянбилгүүн	Санхүү эдийн засгийн дээд сургууль, бизнесийн удирдлага	Хараат	Цалин урамшууллын хорооны дарга
6.	Шараагийн Шинэбаяр	Сэрүүлэг дээд сургууль, бизнесийн удирдлага	Хараат	
7.	Алтангэрэлийн Цэнгэл	ИргУПС, Удирдлагын академи	Хараат	Нэр дэвшүүлэх хороо, аудитын хорооны

				гишүүн
8.	Жаргалсайханы Энхтулга	Санхүү эдийн засгийн дээд сургууль, бизнесийн удирдлага	Хараат бус	Аудитын хороо, цалин урамшууллын хорооны гишүүн
9.	Чулуунбаатарын Оргил	Chinese Culture University, Магистр, мэдээллийн удирдлагын систем	Хараат бус	Нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хорооны гишүүн

## 2.5. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

2019 оны компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилт 561-ийг ачиж өмнөх оын мөн үеийнхээс бараг 2 дахин бага ачилт хийгдсэнг хүснэгт 4-өөс харж болно. Шилжүүлэн ачилт ингэж буурсан нь төмөр замаар тээвэрлэлт хийж байгаа аж ахуйн нэгж ерөнхийдөө буурсан, шилжүүлэн ачилт хийлгэх аж ахуйн нэгж иргэд төмөр замын үйл ажиллагааг дангаараа эрхлэн явуулж байгаа УБТЗ-ийн давуу эрхийн нөлөө, монополь байдал, тухайн компанийн үйл ажиллагааны хүртээмж, чадал зэргээс шалтгаалан тус компанийн шилжүүлэн ачилтын үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлж бууралтын гол шалтгаан болж байна.

Төмөр замын байгууллага болох Улаанбаатар төмөр замын Замын-Үүд өртөө нь шилжүүлэн ачилт хийгддэг гол улирлын үеэр тус компанийн салбар замаар вагон тавьж олгохдоо даруй 2-3 хоног болдог, шилжүүлэн ачилт хийгдсэний дараа салбар замаас ачааг татаж авахдаа мөн төдий удаан хонодог зэргээс шалтгаалан тус салбар замаар шилжүүлэн ачилт хийгдэх иргэн, аж ахуйн нэгж буурч байна. Өнөөгийн байдлаар тус компанийн салбар замаар голцуу яаралтай биш ч тогтмол ачаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжүүд л шилжүүлэн ачилт хийж байна.

Гэхдээ үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа ингэж доголдож байгаа боловч бусад байдлаар өөрсдийн техник тоног төхөөрөмжинд тулгуурлан шилжүүлэн ачилтын үйл ажиллагаа явуулах талаар судлаж үзсэний үндсэн дээр bigbag савалгаатай нурмаг ачааг тээврийн хэрэгслээс тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих талаар харилцагч компанитай гэрээ байгуулан шилжүүлэн ачилтыг эхлүүлээд байна.



Компанийн үндсэн үйл ажиллагаа ингэж доголдож байгаа ч бусад үйл ажиллагаа урьд онуудын мөн үеийнхээс өссөн. 2018 онд гаалийн хяналтын бүсээр үйлчлүүлсэн тээврийн хэрэгсэл 10528 байсан бол 2019 онд 13115 тээврийн хэрэгсэл нэвтэрч үйлчлүүлсэн нь сүүлийн жилүүдэд гарч байгаагүй өссөн дүнтэй байна. Үүнээс гадна 2017 оноос гаалийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн экспортын ачааг тус гаалийн хяналтын бүс дэх баталгаажсан авто пүүн дээр жин тонн, ачаа барааг шалгаж нэвтрүүлж байх ажлын хүрээнд 2018 онд 2056 экспортын ачааг хяналтын бүсээр нэвтрүүлж байсан бол 2019 онд 2555 тээврийн хэрэгсэл пүүлж ажилласан байна.

Гаалийн хяналтын бүс дэх гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа нь сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар болон эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан төдийлөн жигд явагдаж чаддаггүй байсан бол 2018-2019 онуудад тодорхой хэмжээгээр өсч компанийн орлогын тодорхой хувийг эзлэх болсон.

Мөн тус компанийн бусад төрлийн үйлчилгээнээс олох орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 35 хувиар өссөн нь цаашид гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг нэмэгдүүлбэл хяналтын бүс дагасан үйлчилгээнүүдийн үйл ажиллагааг сайжруулах, гаалийн нэг цэгийн үйлчилгээг түшиглэсэн шинэ үйлчилгээг нэвтрүүлснээр бусад төрлийн үйлчилгээнээс олох орлого нэмэгдэж үндсэн үйл ажиллагааны алдагдалд тодорхой хувь нэмэр оруулж болох юм гэж үзэж байна.

Компанийн хяналтын бүсийг стандартын шаардлагад нийцүүлэх, тэнд ажиллагсдын эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс хуучин боомтын талбайд ашиглагдаж байсан даацын хавтанг ашиглан хяналтын бүс орох хэсгээс автопүү хүртэлх газарт хавтангаар зам тавьж ашиглалтанд оруулж энэ ажилд 63 сая төгрөг зарцуулсан бөгөөд 2020 онд энэхүү ажлыг үргэлжлүүлэн зарим талбайг бетонодохоор төлөвлөлөө.

Компанийн орлогод тодорхой хувь нэмэр оруулж байгаа цайны газрын ажилчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, түүгээр үйлчлүүлж байгаа иргэдийн тав тухтай үйлчлүүлэх нөхлийг хангаж үйлчлүүлэгч нарын тоог нэмэгдүүлснээр ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор цайны газрын өргөтгөлийн ажлыг 18,087,440 төгрөгийн ажил хийсэн ба одоо мөн төдий тооны дүнтэй засвар үйлчилгээний ажил хийгдэхээр эхний ээлжийн ажлууд хийгдэж эхлээд байна.

## **2.6. “Компанийн засаглалийн кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан**

Тус компани нь “ Компанийн засаглалийн кодекс “-ийг мөрдөн дагаж ажиллаж байгаа бөгөөд өөрийн компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээ компанийн өөрийн веб сайт, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж, Монголын Компанийн засаглалийн үндэсний зөвлөлийн веб сайтуудад тавьж олон нийт болон хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж байгаа болно.

## **3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**3.1. Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;**

НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн дансуудыг ангилан, туслах дансуудыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан коджуулан хэрэглэж байгаа бөгөөд дансны жагсаалт нь баланс болон орлого, үр дүнгийн тайлангуудын дансуудаас бүрддэг. Санхүүгийн жилийн татвар ногдох орлого, зардлаа Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккруэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор баталгаажуулан Төрийн сан болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг. Мөн бид санхүүгийн тайлангаа өөрийн веб сайтандаа байршуулдаг ба энэ нь манай дотоодын харилцагч нараас гадна дэлхийн аль ч улс орноос харилцагчид санхүүгийн мэдээллийг бодитой, шуурхай авах боломжийг олгодог.

### Санхүүгийн байдал /Аудитлагдсан тайлан/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 30	2019 оны 12-р сарын 30
Эргэлтийн хөрөнгийн дүн	252,834.25	119,913.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,224,311.93	5,102,883.60
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,477,146.18</b>	<b>5,222,796.60</b>
Өр төлбөрийн нийт дүн	516,141.57	427,540.72
Эзэмшигчдийн өмчийн дүн	4,961,004.61	4,795,255.90
<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	<b>5,477,146.18</b>	<b>5,222,796.60</b>

### Орлого үр дүн тайлан /Аудитлагдсан тайлан/

Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	712,587.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0
Нийт ашиг (алдагдал)	712,587.2
Түрээсийн орлого	44,826.3
Хүүний орлого	76.8
Бусад орлого	13,249.9
Ерөнхий ба удирдлагын зардал	893,655.7
Санхүүгийн зардал	32,082.5
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	9.3
Бусад ашиг (алдагдал)	10,752.0
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(165,741.0)
Орлогын татварын зардал	7.7
Татварын дараах ашиг (алдагдал)	(165,741.0)



Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(165,741.0)

### 3.2. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

### 3.3. Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл

Огноо	Зээлийн төлөлт	Үлдэгдэл
Зээлийн эхний үлдэгдэл		200,000,000
19.01.01-19.12.31	36,000,000	0
18.12.25		
Зээлийн үлдэгдэл 2019 оны 12-р сарын 31		164,000,000

Хөрөнгө оруулалтын зорилгоор 5 жилийн хугацаатай сарын 1,5%-ийн хүүтэй 200,000,000 сая төгрөгний зээлийн үлдэгдэл 164,000,000 төгрөг байна.

## 4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### 4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019.04.25-ний өдөр нийт хувьцааны 93.42% буюу 43,192,759 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй хуралдсан. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн 99,99% нь зөвшөөрсөн, 0,00039% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан.
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн 99,99% нь зөвшөөрсөн, 0,00039% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн 99,99% нь зөвшөөрсөн, 0,00039% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг хувьцаа эзэмшигчдийн 99,99% нь зөвшөөрсөн, 0,00039% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- ТУЗ-ын 2019 оны цалин урамшууллын төсвийг батлах тухай асуудлаар хувьцаа эзэмшигчдийн 99,99% нь зөвшөөрсөн, 0,00039% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүдээр Э.Батболд, Ч.Энхболд, Ч.Амарсанаа, Б.Лхагвадорж, Д.Даянбилгүүн, Ш.Шинэбаяр нар, хараат бус гишүүдээр А.Цэнгэл, Ч.Оргил, Ж.Энхтулга нар сонгогдсон.

#### **4.2. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;**

д/д	Овог нэр / хуулийн этгээдийн нэр /	Албан тушаал	Хувьцааны хувь
1.	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2.	Би Ди Сек ХК	Брокер дилер, андеррайтэрийн компани	28.5%
3.	Тасган инвест ХХК		11,08%

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болох Энхболдын Батболд, гишүүн Чулууны Энхболд, Бүрэнмэндийн Лхагвадорж, Данзангийн Даянбилгүүн, Шараагийн Шинэбаяр болон гүйцэтгэх захирал Чулууны Амарсанаа нар нь компанийн хараат гишүүд болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болох Алтангэрэлийн Цэнгэл, Жаргалсайханы Энхтулга, Чулуунбаатарын Оргил нар нь компанийн хараат бус гишүүд болно.

#### **4.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн мэдээлэл;**

Компани нь Э-Транс ХХК, БиДиСек ҮЦК ХК, Тасган инвест ХХК гэсэн 5%-иас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд 2018 оны 06 дугаар сарын 27-ний өдөр Тасган инвест ХХК тус компанийн нийт гаргасан хувьцааны 11,08 хувь буюу 5,117,579 ширхэг хувьцааг эзэмших болж нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон болно.

## **5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### **5.1. Компанийн тухайн жилийн ногдол ашгийн тухай;**

2020 оны 02 сарын 14-нд хуралдсан Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар явуулан ногдол ашгийн тараах эсэх талаар хэлэлцэж 2019 оны үйл ажиллагаа алдагдалтай байсан тул ногдол ашиг тараахгүй байх төлөөлөн удирдах зөвлөлийн 01 тоот тогтоол гаргасан.